



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 82

Чойбалсан

Г

Г

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын "ж" дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ЭНХТӨР

“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ

Хүн амын гуравны нэгийг эзэлж буй хүүхдэд хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцоход чиглэсэн бодлогыг хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцын зарчим, үзэл санаанд нийцүүлэн хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газраас анхааран ажиллаж байна.

Дорнод аймаг Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, хүн амын хөгжил, гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэр, орон нутгийн бодлогын баримт бичгүүдийн үзэл санаанд суурилсан “Хүүхдэд ээлтэй засаглал-2020” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлээ.

Хөтөлбөрийн үр дүнд Дорнод аймагт хүүхдийн төлөөх хөрөнгө оруулалт нэмэгдэж, хүүхдэд чиглэсэн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг дэмжих “Хүүхэд хөгжил” төв 2, “Залуу техникч” клуб, өсвөр үе залуучуудад нөхөн үржихүйн боловсрол олгох “Аз жаргал төв”, “Нэг цэгийн үйлчилгээний төв”, “Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төв”-үүд шинээр нэмэгдсэн.

Мөн хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр шинээр “Нарны хүүхдүүд”, “Эх орны хүү” төсөлт арга хэмжээ, “Хүүхэд эрдэнэ өдөрлөг”, “Тод өнгө Дорнодоос бодит үзүүлэх сургалт”, хүүхдийн эрсдэлийн даатгалын үйлчилгээ, Тэжээлийн дутагдалтай болон суурь өвчлөлтэй хүүхдүүдийн сувиллын үйлчилгээ зэргийг нэвтрүүлснээр хүүхдийн оролцоо, хамрагдалт 2016 онтой харьцуулбал 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дорнод аймгийн хөгжлийн бодлого нь Хүн төвтэй тэр дундаа ирээдүй болсон хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэгдэж байна. Цаашид хүрсэн түвшингээ улам бататгаж хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж тэднийг хөгжүүлэх, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй аюулгүй орчинг бүрдүүлэх нэн чухал хэрэгцээ бий болж байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай хууль тогтоомж болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим

- Хөтөлбөрийн зорилго тодорхой, зорилтууд хэрэгжихүйц байх
- Хүүхдийн эрхийг дээдэлсэн, тэгш хүртээмжтэй байх
- Олон улсын болон Монгол улсын стандартад нийцсэн байх
- Гадаад дотоодын сайн туршлага, жишигт нийцсэн, өндөр бүтээмжтэй, үр дүнтэй байх
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа, үр ашигтай түншлэл, олон нийтийн санаачилга, оролцоонд тулгуурласан байх
- Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоонд тулгуурлах

- Хүүхдийн оролцоог хангасан, тэдний хүсэл сонирхлыг харгалзсан, сонгох боломж олгосон уян хатан байх

Гурав. Хамрах хүрээ

- Нутгийн өөрөө удирдах байгууллагууд /баг, сум, аймаг/
- Аймаг, сумын Хүүхдийн төлөө зөвлөл
- Нутгийн захиргааны байгууллагууд /баг, сум, аймаг /
- Төр, иргэний нийгмийн байгууллагууд
- Сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагууд
- Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд
- Эцэг эх, олон нийт
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд

Дөрөв. Хөтөлбөрийн алсын хараа:

Хүүхдийн эрхэд суурилсан хөгжил, хамгааллын үйлчилгээний сайн загварыг бий болгож, үндэсний түвшинд манлайлан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” болно.

Тав. Хөтөлбөрийн зорилго:

Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангахад эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог салбарын байгууллагуудын оролцоотойгоор сайжруулан хүүхдэд ээлтэй орон нутгийг бэхжүүлэхэд оршино.

Зургаа: “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг 2021-2025 он хүртэл хэрэгжүүлэх зорилт:

1. Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг аливаа хэлбэрийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
2. Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжүүлэхэд мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэх замаар эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлнэ.
3. Засаглалын бүх түвшинд хүүхдийг сонсох, үзэл бодлыг хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэн тэдний оролцоог нэмэгдүүлнэ.
4. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлж, салбарын хоорондын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ

Долоо:

Хугацаа: Энэхүү хөтөлбөрийг 2021-2024 онд дараах 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Үүнд:

- **Нэгдүгээр үе шат:** Хөтөлбөрийн зорилго, зорилтыг гэр бүл, иргэд олон нийтэд сурталчлан таниулах гарааны үе /2021 оны 01-12 сард/
- **Хоёрдугаар үе шат:** Салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааны хүрээнд хөгжил хамгааллын үйлчилгээг хэрэгжүүлэх буюу хэрэгжилтийн үе шат /2022-2023 оны 01-12 сард/
- **Гуравдугаар үе шат:** Хөтөлбөрийн тайлан, үр дүнг тооцох, хяналт шинжилгээ хийх буюу Үр дүн үнэлэх, тайлагнах үе шат /2024 оны 01- 12 сард/

Найм. Хүрэх үр дүн:

- Бүх түвшинд хүүхдийн оролцоо нэмэгдэж, хүүхэд өөрт хамааралтай асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх чадамжтай, өөртөө итгэлтэй, хариуцлагатай, эх оронч сэтгэлгээтэй Зөв Монгол иргэн төлөвшихөд нөлөөлсөн байна.

- Хүүхэд, гэр бүлд хүрэх эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, үр өгөөж 2020 оноос 10.3 хувиар нэмэгдүүлсэн байна.
- Хүүхдийн хөгжил, хамгааллын шинэ үйлчилгээ нэвтэрч, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүх түвшинд бүрдэж, хүүхдийн эрхийн зөрчил 1.5 хувиар буурсан байна.
- Хүний нөөцийн чадавх, салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэл сайжирч, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний стандартыг бүрдүүлсэн байна.

Ес. Удирдлага, зохион байгуулалт:

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь, Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг даргын ажлын алба, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжинэ.

- Төрийн байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст нэгтгэж, аймгийн Засаг даргын зөвлөл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнана.
- Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргаж, цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.
- Холбогдох байгууллагууд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй ололт амжилт, ахиц өөрчлөлт, үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.

Арав. Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл:

1. Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг аливаа хэлбэрийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нэгдүгээр зорилтын хүрээнд:

- 1.1. Эцэг эх, асран хамгаалагч болон багш сурган хүмүүжүүлэгчдэд хүүхэдтэй ажиллах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах
- 1.2. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын түвшинд хүүхэд хамгааллын багийн ажлыг эрчимжүүлэх, хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг баяжуулах замаар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх
- 1.3. Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хуулиар хүлээсэн үүрэг хүлээгчидтэй хамтарсан хүүхэд хамгааллын үйлчилгээг шуурхай хүргэх явуулын баг ажиллуулах "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ" үзүүлэх автобустай болох
- 1.4. "Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх "Зүүн бүсийн төв"-ийг байгуулан төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх
- 1.5. Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх
- 1.6. Сүм хийд, шашны байгууллагад шавилан суудаг хүүхдийн боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, хүүхдийн эрхийг зөрчсөн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцлах, мэдээллийн сан үүсгэх
- 1.7. Хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо хяналтыг сайжруулах хяналт шалгалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах

- 1.8. Сургууль, цэцэрлэг, хүүхдэд үйлчилдэг байгууллага бүр болзошгүй эрсдэлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалах арга зүйд суралцах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- 1.9. Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн, чуулганыг жилд 1 удаа зохион байгуулах
- 1.10. Хамтарсан багийн үйл ажиллагааг санхүүжүүлэх замаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг сайжруулах, урамшуулах механизмаар гишүүдийн үүрэг оролцоо хариуцлагыг нэмэгдүүлэх

2. Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжүүлэхэд мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэх замаар эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд:

- 1.11. Хөгжих, хамгаалуулах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд нэг бүрд тэгш, хүртээмжтэй хүргэдэг "Хүүхдэд ээлтэй баг, сум, байгууллага" болох хөдөлгөөнийг өрнүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх
- 1.12. Байгууллага, аж ахуйн нэгжүүд дэргэдээ албан хаагчдынхаа хүүхдүүдийн өдөр өнжүүлэх төвтэй болох хөдөлгөөн өрнүүлэх
- 1.13. Сум багийн өрхийн эмнэлэг болон цэцэрлэг, сургууль бүр "Эрүүл хүүхэд", "Эрүүл шүд" аяныг тогтмолжуулж бага насны хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эцэг эх, олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
- 1.14. Тэжээлийн доройтолтой, суурь өвчтэй хүүхдүүдийг жил бүр зуны сувилалд сувилж, бага насны хүүхдийн өвчлөлийг бууруулан, эрүүл мэндийн дархлааг сайжруулах
- 1.15. Өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэнд боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубийн сурагчдыг "Өсвөрийн зөвлөгч"-өөр бэлтгэх
- 1.16. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд зориулсан ээлтэй орчин бүрдүүлэх, нийгмийн хандлагыг өөрчлөх сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
- 1.17. Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг үе шаттай зохион байгуулах, аюулгүй байдлын төлөө хөршөөр хамтран ажилладаг арга барилыг нэвтрүүлэх
- 1.18. Хүүхдийн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр "Эцэг эх-зохицуулагч" арга хэмжээг эрчимжүүлж, "Хүүхдийн зориулалттай автомашины суудал" хэрэглэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцох эерэг дадлыг хэвшүүлэх ажлыг зохион байгуулах
- 1.19. Хүүхэд, өсвөр үеийнхэнд гар утасны болон цахим сүлжээ ашиглалтын зөв хэрэглээг хэвшүүлэхэд үе тэнгийнхний оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, эцэг эх, олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах
- 1.20. Хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй байгууллага, иргэн хуулийн этгээд, хүүхдийн тоглоомын талбайн стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулах

2. Засаглалын бүх түвшинд хүүхдийг сонсох, үзэл бодлыг хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэн оролцоог нэмэгдүүлэх" гуравдугаар зорилтын хүрээнд:

- 1.21. Хүүхдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх клуб, дугуйлангууд, хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллагуудын нэгдсэн, хамтын үйл ажиллагааг нь дэмждэг “Хүүхэд хөгжлийн ордон”-той болох
- 1.22. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, багийн ажлын алба, албан байгууллага, сургууль бүр “Хүүхдээ сонсох өдөр”-ийг эрчимжүүлж, хүүхдээс гарсан санал хүсэлтийг төсвийн төлөвлөлт, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх
- 1.23. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, клубын гишүүдийг чадавхжуулах, шинэ санаачилгыг дэмжих, урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зарчмаар хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх
- 1.24. Хичээлээс гадуурх дугуйлан, клуб олноор хичээллүүлэх, хүүхдийн сонирхол хэрэгцээнд тулгуурласан ардын дуу хөгжим, цирк, усан спорт зэрэг шинэ нэр төрлийн дугуйлан клуб байгуулах замаар хүүхдийн авьяас, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх
- 1.25. Бүс, улс, олон улсын шинж чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах нэн ялангуяа багийн спорт, урлагийн тоглолтыг хөхүүлэн дэмжих
- 1.26. Хөрш зэргэлдээ улсуудын болон хөдөө орон нутгийн онцлог, үндэстэн ястны соёл, өв уламжлалаас суралцах, хамтын ажиллагаа нөхөрлөлийг бэхжүүлэх улмаар хүүхдэд багаас нь багаар ажиллах чадварыг эзэмшүүлж, тэдний хүсэл сонирхол, хэрэгцээнд тохирсон хөгжлийн шаталсан хөтөлбөрт үйл ажиллагаанд хамруулах, танин мэдүүлэх зорилго бүхий “Нарны хүүхдүүд” сурагч солилцооны төсөлт ажлыг зохион байгуулах
- 1.27. Хүүхдэд бага наснаас нь эхлэн гэр бүлийн боловсрол олгох хариуцлагатай эцэг эх хөгжиж төлөвшсөн хүүхэд, залуучуудыг бий болгох замаар хүүхдийн хүмүүжил төлөвшилд нөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах
- 1.28. Зүүн бүсийн хүүхдийн чуулганыг 2 жилд нэг удаа, сум бүр хүүхдийн чуулганыг 2 жилд нэг удаа зохион байгуулж, хүүхдийн саналаар Хүүхдийн элчийг сонгож ажиллуулах, үйл ажиллагааг дэмжих
- 1.29. Гэр бүлийн гишүүдийг оролцуулсан чуулга уулзалт, сургалт хэлэлцүүлэг, соёл урлаг, уламжлалт зан заншилтай холбоотой / Ихрүүдийн баяр, ургийн баяр, уртын дуу, морь, бөх цоллогчийн уралдаан, ардын тоглоом наадгай/ олон талт арга хэмжээг зохион байгуулах
- 1.30. Хүүхэд, багачуудад байгаль дэлхий, эх орон, төрөлх нутгаа хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилгоор хөдөлгөөн, хүүхдийн чуулган, төсөлт ажлыг зохион байгуулах, байгальд ээлтэй өсвөр үеийг бэлтгэх
- 1.31. Өсвөр насны хөвгүүдэд цэрэг эх оронч хүмүүжлийг олгох зорилгоор мэргэжлийн байгууллага, ахмад дайчид, түүх судлаачдыг түшиглэн жил бүр “Эх орны хүү” хөтөлбөрт ажлуудыг зохион байгуулах
- 1.32. Хэвлэл мэдээлэл дэх хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд Монгол ахуй, ёс заншил, үлгэр домог, зүйр цэцэн үгээр дамжуулан хүүхдэд зөв хүмүүжил төлөвшил олгох бүх төрлийн контент, нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэх “Жиргээ” хүүхдийн студийг байгуулах.

2. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлж, салбарын байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

- 1.33. Сургууль, цэцэрлэг, хүүхдэд үйлчилдэг байгууллага бүр дагаж мөрдөх “Хүүхэд хамгааллын бодлого”-ын дагуу хүүхэд хамгааллын зөвлөл /хороо/ байгуулж, хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл, аюул эрсдэлээс урьдчилан

- сэргийлэх, холбоотой санал, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх, эцэг эх, гэр бүлийн гишүүдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх
- 1.34. Хүүхдийг аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд эцэг эх, сургуулийн дотуур байр, анги удирдсан багш, нийгмийн ажилтнуудын үүрэг оролцоог нэмэгдүүлж, аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Хүүхдийн хууль зүйн хороо болон Хамтарсан багтай хамтран ажиллах
- 1.35. Хүчирхийллийн хохирогч хүүхдэд хууль эрх зүйн дэмжлэг, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх өмгөөлөгч, хууль эрх зүйн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах
- 1.36. Сургууль, цэцэрлэг бүр хүүхдийн хичээлээс гадуурх хүмүүжил, хөгжлийн ажлын шинэ арга зүйг нэвтрүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, төвүүдийн үйл ажиллагааг дэмжих
- 1.37. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын чиглүүлэгч багш нарт урамшуулал олгох, улс, бүс, олон улсын уулзалт сургалтуудад үе шаттай хамруулж чадавхжуулах
- 1.38. Сургуулийн нийгмийн ажилтан, эмч, дотуур байрны багш, жижүүр, үйлчлэгч нарыг хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад үе шаттай хамруулж чадавхжуулах
- 1.39. Хэвлэл мэдээлэлд тавигдах ёс зүйн хэм хэмжээ стандарт шаардлагын хүрээнд орон нутгийн хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын хүүхэд хамгааллын асуудлаар мэргэших сонирхлыг дэмжих, урамшуулах
- 1.40. Насанд хүрээгүй хүний гэмт хэрэгтэй ажилладаг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч нарт Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрх, хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм журмаар хэлэлцүүлэг, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах
- 1.41. Дорнод Их сургуулийг түшиглэн сум, баг, сургуулийн нийгмийн ажилтнуудыг хүүхэд, гэр бүлийн сэтгэл зүйн чиглэлээр мэргэшихэд дэмжлэг үзүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх мэргэжлийн үйлчилгээний чанарыг сайжруулах

Арван нэг. Хөтөлбөрийн санхүүжилт

- Улсын төсөв /Улсын төсөвт төсвийн байгууллагууд салбарын бодлого, төсвийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлнэ/
- Орон нутгийн төсөв
- Орон нутгийн хөгжлийн сан
- Олон улсын байгууллагын дэмжлэг, төсөл хөтөлбөр
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, компани, иргэдийн тусламж дэмжлэг, хандив

Арван хоёр. Хяналт, шинжилгээ үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, нэмэлт өөрчлөлт оруулж болно. Сумын Засаг даргын Тамгын газар болон Төрийн байгууллагууд өөрийн чиглэлийн үйл ажиллагааны хүрээнд үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан гарааны үнэлгээ хийх ба жил бүр үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр хийж, ахиц өөрчлөлтийг тооцож ажиллана. Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, хөтөлбөрийн эцсийн шатны үнэлгээг Засгийн газраас баталсан нийтлэг журмын дагуу гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ тайланг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд, ил тод, нээлттэй мэдээлнэ. www.dornod@fcy.gov.mn; www.Дорнод Хүүхэд Гэр бүл/ Арван гурав. Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь	Хүрэх түвшин				
			2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	
Зорилт 1: Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг аливаа хэлбэрийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нэгдүгээр зорилтын хүрээнд:								
1	Хүүхэд, гэр бүлд зориулсан хөгжил хамгааллын үйлчилгээ, сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	39.7%	45	45	50	50	
2	“Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ” үзүүлэх автобустай болох	Автобуст ай болсон эсэх Тоо	0	0	1	1	1	
3	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх төвийн тоо	Тоо	0	1	0	0	1	
4	Хамтарсан багийн гишүүдийн үүрэг оролцоо хариуцлагыг нэмэгдүүлэх	Кейс шийдвэрлэлтийн хувь	75 хувь	85 хувь	90 хувь	95 хувь	95 хувь	
Зорилт 2: Хүүхдийг эрүүл ,аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжүүлэхэд мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэх замаар эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлнэ.								
1	“Эрүүл хүүхэд”, “Эрүүл шүд” аяныг тогтмолжуулж бага насны хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдан хүүхдийн эзлэх хувь	Эзлэх хувь	20.2 хувь	21 хувь	22 хувь	24 хувь	25 хувь	

2	Зуны сувилалд хамрагдсан хүүхдийн тоо	Тоо	1010	1000	1000	1000	4000
3	Хүүхдийн төлөө хийгдсэн бүтээн байгуулалтад тусгагдсан хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь	2.5 хувь	2.7 хувь	2.8 хувь	3.0 хувь	3.2 хувь
4	"Хүүхдэд ээлтэй баг, сум, байгууллага"-ын болзол хангасан тоо	Тоо	2	8	15	20	24

Зорилт 3: Засаглалын бүх түвшинд хүүхдийг сонсох, үзэл бодлыг хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэн оролцоог нэмэгдүүлэх " гуравдугаар зорилтын хүрээнд:

1	Хүүхдийн хөгжлийн дугуйлан, сургалтын тоо	Тоо	121	125	130	135	140
2	Хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	48 хувь	40 хувь	42 хувь	48 хувь	50 хувь
3	Хүүхдийн оролцооны байгууллагад хамрагддаг байгууллага, хүүхдийн тоо	Тоо	82 байгууллагад 2156	82/2200	85/2300	85/2350	85/2500
4	"Жиргээ хүүхдийн студи" байгуулах	Тоо	0	1	-	-	1

Зорилт 4. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлж, салбарын байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

1	Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдаан, шийдвэрийн тоо	Тоо	14 хуралдаан 27	14 Хуралдаан 30	14 Хуралдаан 30	14 Хуралдаан 30	14 Хуралдаан 35
2	Хүүхэд хамгааллын зөвлөл /хороо/ байгуулж, хүүхэд хамгааллын багийн эзлэх	Хувь	80%	80%	90%	90%	100%

---oOo---